

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зорчигч тээвэр тав ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2025/99/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он	Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга: Ч.Болд Утас: 7000-7734 Цахим хаяг: boldch@audit.gov.mn
	Санхүү-Нийцлийн аудитын хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
	Аудитын менежер: Д.Отгонбаяр Утас: 325093 Цахим хаяг: otgonbayard@audit.gov.mn
	Ахлах аудитор: М.Ундармаа Утас: 325093 Цахим хаяг: undarmaam@audit.gov.mn Аудитор: Н.Түмэнжаргал Утас: 325093 Цахим хаяг: tumenjargaln@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025.03.14 № 01/220
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН ЗОРЧИГЧ
ТЭЭВЭР ТАВ ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА С.БАТЗАЯА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Зорчигч тээвэр тав ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Компанийн удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус компанийн талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул компанийн тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Тайлант онд 16,793,926.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 16,587,523.4 мянган төгрөгийг зарцуулж, 206,402.8 мянган төгрөгийн ашигтай ажиллаж, төлөвлөгөөт алдагдлын хэмжээг 4,961,996.4 мянган төгрөгөөр бууруулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2024 оны 28 дугаар тогтоолоор Зорчигч тээвэр тав ОНӨААТҮГ байгуулагдаж 2024 оны 6 дугаар сараас үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна.

C:\Users\zendmene.d\Desktop\2025\Word\Yvsn by 20250314 1425010182

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 97 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 95.6 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	0.00	429,880,023.79
1.1.02	Дансны авлага	0.00	2,815,415,509.10
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	0.00	82,389,136.67
1.1.04	Бусад авлага	0.00	17,201,911.43
1.1.06	Бараа материал	0.00	1,224,744,823.53
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	0.00	4,569,631,404.52
1.2.01	Үндсэн хөрөнгө	0.00	102,224,380,632.74
1.2.02	Биет бус хөрөнгө	0.00	7,662,522,807.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	0.00	109,886,903,439.74
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	114,456,534,844.26
2.1.1.01	Дансны өглөг	0.00	2,951,471,806.01
2.1.1.03	Татварын өр	0.00	5,446,822.83
2.1.1.04	НДШ - ийн өглөг	0.00	3,265,442.84
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	0.00	2,960,184,071.68
2.1.2.04	Бусад урт хугацаат өр төлбөр	0.00	28,572,117,466.62
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	0.00	28,572,117,466.62
2.2	Өр төлбөрийн нийт дүн	0.00	31,532,301,538.30
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	0.00	82,717,830,503.73
2.3.09	Хуримтлагдсан ашиг	0.00	206,402,802.23
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	206,402,802.23
2.3.11	Эздийн өмчийн дүн	0.00	82,924,233,305.96
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	0.00	114,456,534,844.26

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)		16,789,727,658.86
2	Борлуулалтын өртөг		7,921,362,340.67
3	Нийт ашиг(алдагдал)		8,868,365,318.19
5	Хүүгийн орлого		4,198,508.91
8.1	Орлогын дүн		4,198,508.91
9	Борлуулалт, маркетингийн зардал		6,532,712,225.49
10	Ерөнхий ба удирдлагын зардал		2,133,448,799.38
12.1	Зардлын дүн		8,666,161,024.87
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		206,402,802.23
20	Татварын дараах ашиг (алдагдал)		206,402,802.23
22	Татварын үеийн ашиг (алдагдал)		206,402,802.23

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	-	-	-	-	-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
3	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	206,402,802.23	206,402,802.23
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
6	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	82,717,830,503.73	-	82,717,830,503.73
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	--
9	2024 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	-	-	82,717,830,503.73	206,402,802.23	82,924,233,305.96

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	12,416,510,025.09
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	-	10,640,076,541.60
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	14,055,652.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	-	1,762,377,831.49
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	11,644,420,796.30
1.2.1	Ажиллагчдад төлсөн	-	5,536,909,014.76
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	-	1,595,335,115.59
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	-	729,012,201.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	-	108,001,503.35
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-	2,499,799,735.30
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	-	687,183,991.24
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	-	160,089,704.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	-	328,089,531.06
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	772,089,228.79
2			
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	342,209,205.00

2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	342,209,205.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	- 342,209,205.00
3			
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-	429,880,023.79
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	429,880,023.79

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2024 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Эдийн засгийн үзүүлэлт	2024 оны зорилт	2024 оны гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	1. Нийт орлого	14,845,403.3	16,793,926.2	1,948,522.9	113%
1.1	Шугамын орлого	1,957,959.4	968,157.5	-989,801.8	49%
1.2	Санхүүжилтын орлого	11,298,151.2	14,287,465.0	2,989,313.8	126%
1.3	Нөхөн олговор	1,247,292.7	1,021,430.7	-225,862.0	82%
1.4	Бэлэн мөнгөний орлого	300,000.0	57,218.1	-242,781.8	19%
1.5	Сургуулийн автобусны орлого		455,456.2	455,456.2	100%
1.6	Үйл ажиллагааны бусад	42,000.0	4,198.5	-37,801.5	10%
	2. Нийт зардал	19,600,996.9	16,587,523.4	3,013,473.5	85%
2.1	Цалин	5,828,933.6	6,846,037.9	-1,017,104.3	117%
2.2	НДШ	832,070.6	861,531.4	-29,460.8	104%
2.3	Шатахуун	6,410,090.3	4,375,888.4	2,034,201.9	68%
2.4	Тосолгооны материал	396,199.4	181,139.3	215,060.1	46%
2.5	Сэлбэг хэрэгсэл	904,811.3	260,931.6	643,879.7	29%
2.6	Багаж тоног төхөөрөмж		3,206.4	-3,206.4	100%
2.7	Аккумулятор		-	-	
2.8	Дугуйн зардал	63,300.0	-	63,300.0	0%
2.9	Хөдөлмөр хамгаалал	247,128.0	392	246,736.0	0%
2.1	Үндсэн хөрөнгийн элэгдэл	2,527,730.7	3,202,376.6	-674,645.9	127%
2.11	Бичиг хэрэглэл	16,432.0	18,859.1	-2,427.1	115%
2.12	Хангамжийн зардал	117,413.9	221,722.3	-104,308.4	189%
2.13	Эм эмнэлэгийн хэрэгсэл		-	-	
2.14	Ариун цэврийн зардал	57,401.4	-	57,401.4	0%
2.15	Засвар үйлчилгээ	169,813.0	10,967.4	158,845.6	6%
2.16	Цахилгаан	83,431.4	51,973.8	31,457.6	62%
2.17	Ус	24,238.9	11,098.6	13,140.3	46%
2.18	Халаалт дулаан	177,721.7	32,939.1	144,782.6	19%
2.19	Харилцаа холбоо	36,010.0	15,558.8	20,451.2	43%
2.2	Үндсэн хөрөнгийн татвар	9,162.9	-	9,162.9	0%
2.21	Газрын төлбөр	7,473.5	2,174.8	5,298.7	29%
2.22	Тээврийн хэрэгслийн татвар (гэрчилгээ, дугаар)	4,930.0	1,103.5	3,826.5	22%
2.23	Даатгалын үйлчилгээ	193,342.7	160,089.7	33,253.0	83%
2.24	Сургалт, сурталчилгаа	31,400.0	21,954.0	9,446.0	70%
2.25	Албан томилот	31,754.8	31,055.7	699.1	98%
2.26	Тэтгэвэр тэтгэмж, шагнал	47,600.0	12,665.7	34,934.3	27%

2.27	Гадны үйлчилгээ	205,220.2	213,198.4	-7,978.2	104%
2.28	Үйл ажиллагааны бусад	319,678.0	26,208.8	293,469.2	8%
2.29	Холбоо түүвэр (IT зардал)	266,122.8	9,050.0	257,072.8	3%
2.3	Хөрөнгө оруулалтын зардал	561,735.8	-	561,735.8	0%
2.31	Хэвлэл мэдээлэл, сурталчилгаа	29,850.0	15,400.0	14,450.0	52%
3. Цэвэр ашиг, алдагдал		-4,755,593.6	206,402.8	-4,961,996.4	-4%
ОНТНЗ		1.32	0.99	0.33	75%
Нийт авлага			2,815,415.5		
Нийт өр төлбөр			31,532,301.5		

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 82,717,830.5 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Аудитаар нийт 221,059.9 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 2,100.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 218,959.9 мянган төгрөгийн зөрчилд 7 зөвлөмж өгсөн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл. Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Д. д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Өмчийн өөрчлөлтийн тайланд өмчид гарсан өөрчлөлтийг дутуу илэрхийлсэн.	1	82,717,830.5	1	82,717,830.5			1	82,717,830.5				
	Дүн	1	82,717,830.5	1	82,717,830.5			1	82,717,830.5				

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Автобусны өдөр тутмын бэлэн мөнгөний орлогыг мөнгөн гүйлгээний тайланд	1	106,744.3					1	106,744.3				

	тайлагнаагүй. Бэлэн мөнгөөр автобусны төлбөр авсаар байна.												
2	Автобусны жолооч нарын бэлэн мөнгө гар дээр авсан зөрчлийг цалингаас суутгал хийж, орлогоор бүртгэлгүй цалингийн зардлыг бууруулж бүртгэсэн байна.	1	2,661.8					1	2,661.8				
3	Тайлант онд өр төлбөрийн үлдэгдэлтэй гарсан байна.	1	8,712.3					1	8,712.3				
4	Авлага барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна.	1	99,591.1					1	99,591.1				
5	Гэрээ байгуулалгүйгээр бусдаар гүйцэтгүүлэн ажлын хөлс олгосон	1	2,100.0	1	2,100.0								
6	Тэнүүн-Огоо ХХК-аас шилжиж ирсэн хөрөнгийг байгууллагын нэр дээр шилжүүлээгүй байна.	1	-					1	-				
7	Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг дахин үнэлж бүртгээгүй байна.	1	-					1	-				
8	Шатахууны тооцооны хуудас дутуу бөглөсөн, автомашины зөвшөөрлийн хуудас бөглөдөггүй.	1	1,250.4					1	1,250.4				
	Дүн	8	221,059.9	1	2,100.0			7	218,959.9				

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Шилэн дансанд 3 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг оруулаагүй байна.	1	-					1	-
2	Шаардлагагүй бараа, материал их хэмжээгээр бэлтгэж нөөцөлсөн.	1	3,750.0			1	3,750.0		
3	Тайлант онд холбогдох хууль тогтоомжийн дагуу цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй байна.	1	249,289.5					1	249,289.5
	Дүн	3	253,039.5			1	3,750.0	2	249,289.5